

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА /дэлгэрэнгүй/

Хуулийн төслийн төслийг дараах асуудлыг тусган боловсрууллаа.

“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа”-г шинээр томъёолж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар тогтоолд заасан үндэслэл зэргийг судлан үзэж одоо байгаа практикт нийцүүлэн өргөжүүлэн тусгалаа. Үүнд шүүгч, прокурор, шүүгчийн туслахаар ажиллах, нотариатчийн, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийн багш, төрийн байгууллага, хуулийн этгээдэд хуульч ажиллахаар заасан ажил, албан тушаалуудыг хамааруулахаар тусгалаа.

Түүнчлэн эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад чанарыг шаардлагыг нэмэгдүүлэх зорилгоор үндсэн ангийн сургалтын хөтөлбөрөөр эрх зүйч бэлтгэхэд бакалавр, эчнээ, оройн сургалтын хөтөлбөрөөр суралцагчид дэд бакалавр зэрэг олгохоор тусгалаа. Эчнээ, оройн сургалтын хөтөлбөрөөр суралцаж дэд бакалавр зэрэг авсан этгээд нь үргэлжлүүлэн суралцаж, энэ хуульд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр бакалаврын зэрэг авч болно. Энэ нь Дээд боловсролын тухай хуулийн зохицуулалттай уялдан хэрэгжих боломжтой юм.

Эрх зүйн бакалаврын хөтөлбөр нь суралцагчаас Дээд боловсролын тухай хуульд заасан багц цагийн хүрээнд судлах ерөнхий суурь хичээлээс гадна хууль зүйн мэргэжлийн боловсролыг эзэмшүүлэхэд чиглэсэн хичээлийг 90-ээс доошгүй багц цаг судлахыг шаардах, суралцагч хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх хичээлийг хууль зүйн сургуульд гурваас доошгүй жил судлах шаардлагыг тусгалаа.

Дээд боловсролын тухай хуулиар эрх олгогдсоны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар тушаалаар Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг батлан мөрдөж байна.¹ Эрх зүйч бэлтгэх дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн багц цагийн заавал судлах болон сонгон судлах хичээлийн 40 хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байх бөгөөд суралцагч энэ хуулийн дагуу хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшиж төгсөхдөө судалсан нийт багц цагийн 30-аас доошгүй хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байх зохицуулалтыг сайдын тушаалд найдан зохицуулалтгүй үлдээх боломжгүй гэж үзэн хуулийн төсөлд тусгайлан тусгалаа. Ингэхдээ Дээд боловсролын тухай хуулийн сайдад эрх олгосон

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140164626911&showType=1>

заалт бүхий хэсэгт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрөөр зааж болох агуулгыг нэмэхээр тусгасан болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуульд заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн байна. Магадлан итгэмжлэлийг Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэх ажлын хэсэг байгуулах замаар хэрэгжүүлнэ. Магадлан итгэмжлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хуульч эрдэмтэд, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр бүхий хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл ажиллана.

Магадлан итгэмжлэх ажлын хэсгийн ажиллах журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэлийн төлбөрийн хэмжээг Хуульчдын холбооны саналыг үндэслэн хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгалаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь эрх зүйн шинэтгэлийн бодлогын асуудлыг эрхлэн хариуцдагийн хувьд хуульч бэлтгэх үйл ажиллагаанд бодлогоор оролцох нөхцөлийг хангаж ийнхүү хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг батлахад боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтрах агуулгаар тусгалаа.

Магадлан итгэмжлэл хийлгэхээр хүсэлт гаргасан хууль зүйн сургууль энэ хуулийн 58.2-т заасан сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын дийлэнх шаардлагыг хангасан бөгөөд цаашид хоёр жилээс ихгүй хугацаанд шаардлагыг бүрэн хангах талаар үндэслэл бүхий төлөвлөгөө, хүсэлт ирүүлсэн тохиолдолд тухайн хөтөлбөрийг тодорхой болзолтойгоор магадлан итгэмжилж болохоор тусгалаа.

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА /товч/

Хуулийн төслийн төслийг дараах асуудлыг тусган боловсрууллаа.

“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа”-г шинээр томъёолж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар тогтоолд заасан үндэслэл зэргийг судлан үзэж одоо байгаа практикт нийцүүлэн өргөжүүлэн тусгалаа.

Түүнчлэн эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад чанарыг шаардлагыг нэмэгдүүлэх зорилгоор үндсэн ангийн сургалтын хөтөлбөрөөр эрх зүйч бэлтгэхэд бакалавр, эчнээ, оройн сургалтын хөтөлбөрөөр суралцагчид дэд бакалавр зэрэг олгохоор тусгалаа. Эчнээ, оройн сургалтын хөтөлбөрөөр суралцаж дэд бакалавр зэрэг авсан этгээд нь үргэлжлүүлэн суралцаж, энэ хуульд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр бакалаврын зэрэг авч болно. Энэ нь Дээд боловсролын тухай хуулийн зохицуулалттай уялдан хэрэгжих боломжтой юм.

Дээд боловсролын тухай хуулиар эрх олгогдсоны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар тушаалаар Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг батлан мөрдөж байна.² Эрх зүйч бэлтгэх дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн багц цагийн заавал судлах болон сонгон судлах хичээлийн 40 хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байх бөгөөд суралцагч энэ хуулийн дагуу хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшиж төгсөхдөө судалсан нийт багц цагийн 30-аас доошгүй хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байх зохицуулалтыг сайдын тушаалд найдан зохицуулалтгүй үлдээх боломжгүй гэж үзэн хуулийн төсөлд тусгайлан тусгалаа. Ингэхдээ Дээд боловсролын тухай хуулийн сайдад эрх олгосон заалт бүхий хэсэгт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрөөр зааж болох агуулгыг нэмэхээр тусгасан болно.

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140164626911&showType=1>

Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуульд заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн байна. Магадлан итгэмжлэлийг Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэх ажлын хэсэг байгуулах замаар хэрэгжүүлнэ. Магадлан итгэмжлэх ажлын хэсгийн ажиллах журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэлийн төлбөрийн хэмжээг Хуульчдын холбооны саналыг үндэслэн хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгалаа.

--o0o--